

2012 оны Сургуулийн танилцуулга

Токио Гакүгэй Их Сургуулийн харьяа

Коганэй Бага Сургууль

Боловсролын зорилт

Өөдрөг сэтгэлгээтэй, бусдыг хайрлан хүндэтгэдэг хүүхэд,

Бие сэтгэлийн тэнхээтэй хүүхэд,

Тунгааж боддог хүүхэд төлөвшүүлнэ.

■Манай сургуулийн 3 онцлог

○Оюутны багшлах дадлагын түшиц бааз болдог.

Токио Гакүгэй Их сургууль нь багш бэлтгэхийг гол зорилго болгосон сургууль юм. Тиймээс манай сургууль жил бүр олон оюутныг багшлах дадлага хийлгэж, тэд нарыг удирдан сургаж, их сургуулийн багш бэлтгэх сургалтын явцад нэгэн үүрэг гүйцэтгэж ажилладаг. Багшлах дадлагад хамрагдаж байх хугацаанд тэдгээр залуухан, идэвхтэй оюутнууд манай сургуулийн багш нарын удирдлаган дор хичээлийн судалгаа хийдэг. Мөн их сургуулийн хичээл тус бүрийн дидактикийн лекц, багшлах дадлагын урьдчилсан ба дараах удирдамж зөвлөгөө авах үе, сургууль дахь үйлдвэрлэлийн дадлагын ажлын үе г.м.-ээр олон оюутан манай сургуульд ирж, хичээлийн ажилглалт хийх ба багшид туслаж ажиллах явцад хичээлийг зохион байгуулах арга ба заах арга зүйд суралцдаг.

○Боловсролын сэдэвт судалгааны туршилт хийж• үр дүнгийг нь баталдаг.

Энэ оны хичээлийн жилд “хүүхэд тус бүр• анги бүлэг болон сургуулийн төвшинд харилцан суралцаж, бие биеэ түшиж дэмжиж чаддаг болцгооё” хэмээн боловсролын зорилтыг тавьж сургалтын үйл ажиллагаагаа явуулж байна. Багш нар хүүхдүүдтэй ажиллах явцад мэргэжлийн ур чадвараа улам дээшлүүлж, мэргэшилдээ тулгуурлан хичээл заахыг гол чиглэл болгож өдөр тутмын сургалтын үйл ажиллагааг явуулж байна.

Коганэйгийн бүс нутагт оршдог харьяа сургууль ба хүүхдийн цэцэрлэгийн хувьд "Коганэй бүс нутгийн их сургууль ба харьяа сургууль, хүүхдийн цэцэрлэг хамтарч, баклавр• магистр докторын оюутнуудын хөгжлийн шатанд нийцүүлсэн, багш бэлтгэх олон янзын хөтөлбөрийг бий болгох” хэмээн зорилго тавьж ажиллаж байна. Баклавр• магистр докторын оюутнууд, улмаар одоо багшилж буй багш-судлаачид г.м.-ийг тасралтгүй, идэвхтэй хүлээн авч, баклавр болон магистр докторын сургуулийн сургалтын үйл ажиллагааны нэг хэсгийг хариуцан гүйцэтгэхийн зэрэгцээ их сургуулийн багш нарын хэрэгцээний дагуу хүн бүрийн судалгааны

ажлыг дэмжиж ажиллаж байна.

○Их байгальд хоногоор аялалд явах хөтөлбөр зохион байгуулдаг.

Манай сургуулийн 80 орчим жилийн түүх болон заншлыг залгамжлан зохион байгуулдаг хөтөлбөр нь 3-р ангиас эхлэх хоногоор аялалд явах хөтөлбөр юм. Энэхүү аяллын зорилго нь хүүхдүүдийг их байгаль дээр хамтран амьдарснаар бие биеэ дэмжих, сэтгэл биеэ хөгжүүлэх, амьдрах чадвартай болгоход оршино. Боловсролын зорилтын нэг болох “бие сэтгэлийн тэнхээтэй хүүхэд” төлөвшүүлэхэд хоногоор аялалд явах хөтөлбөр их ач холбогдолтой юм.

■Багш· сурагчийн тоо (2012.4.1 байдлаар)

Захирал	1
Дэд захирал	1
Хичээлийн эрхлэгч	1
Багш	26
Хоол тэжээлийн багш	1
Цагийн багш г.м.	11
Бичиг хэргийн ажилтан	3
Үйлчлэгч	5

Анги	Бүлгийн тоо	Эр	Эм	Нийт
1	3	53	50	103
2	3	58	60	118
3	3	60	59	119
4	4	79	79	158
5	4	79	77	156
6	4	79	79	158
Нийт	21	408	404	812

■Цагийн хуваарь

	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
8 : 30 хичээл эхлэх	Өглөөний бие даалт			Цуглаан	Өглөөний бие даалт
8 : 50-9 : 35					
9 : 35-10 : 20					
	Өглөөний уулзалт	Их завсарлага			
10 : 40-11 : 25					
11 : 25-12 : 10					
	Өдрийн хоол· Өдрийн завсарлага				
13 : 15-14 : 00					
14 : 00-14 : 45				Дугуйлан· Хороодын үйл ажиллагаа г.м.	
	Цэвэрлэгээ· хичээл тарах· гэртээ харих (15 : 45)				Цэвэрлэгээ · харих

■Гол үйл

явдал

4 сар	Хичээлийн шинэ жилийн эхлэлийн ёслол (4/6), сургуульд орох ёслол, 1-р ангийн хүүхдүүдийг хүлээж авах цуглаан, эрүүл мэндийн үзлэг, эцэг эхийн хичээлийн ажиглалт, эцэг эх багш нарын ерөнхий хурал
-------	--

5 сар	1-р ангийн экскурс, 5-р ангийн хоногоор аялалд явах хөтөлбөр, аюулгүй байдлын хичээл
6 сар	4-р ангийн хоногоор аялалд явах хөтөлбөр, усанд сэлэх хичээл эхлэх
7 сар	Энхий улирал дуусах ёслол (7/13), усны сэлэлтийн тэмцээн, 3- 5- 6-р
8 сар	ангийн хоногоор аялалд явах хөтөлбөр
9 сар	Зуны амралт (7/17 ~ 8/28) Хичээлийн шинэ улирал эхлэх ёслол (8/29)
10 сар	Усанд сэлэх хичээл дуусах, оюутны багшлах дадлага, 1- 2-р ангийн
11 сар	
12 сар	экскурс, 6-р ангийн хоногоор аялалд явах хөтөлбөр Оюутны багшлах дадлага, биеий тамирын өдөрлөг Бага ангийн намрын баяр, хөгжмийн концерт, шинэ 1-р ангийн хүүхдүүдийн эрүүл мэндийн үзлэг
1 сар	Нийгмийн ухааны хичээлээр ажиглалтад явах (3-6-р анги), 2-р улирал дуусах ёслол (12/21)
2 сар	
3 сар	Өвлийн амралт (12/25-1/7) 3-р улирал эхлэх ёслол (1/8) Хичээлийн семинар, оюутны багшлах дадлага, том ангийн спортын тэмцээн, Төгсөх ангийг үдэх спортын тэмцээн 6-р ангийг үдэх цуглаан, төгсөлтийн ёслол, 3-р улирал дуусах ёслол (3/19)

■Өнөөг хүртэлх хугацаанд хийж ирсэн судалгааны ажлын үр дүн

- Судалгааны сэдэв “Гүнзгийрүүлсэн сургалт” (1967-1973 оны хичээлийн жил)

Гүнзгийрүүлсэн сургалтын хүрээнд төлөвлөх- хичээл заах -үнэлэх хэмээн циклийг төгөлдөлжүүлж, “гүнзгийрүүлсэн сургалт”, “гүнзгийрүүлэн суралцах чадварыг хөгжүүлэх сургалт –гүнзгийрүүлсэн сургалтын практик”, “ гүнзгийрүүлэн суралцах чадварын үнэлгээ” хэмээн 3 цуврал номыг хэвлэн гаргасан.

- Судалгааны сэдэв “Ёс зүй, гоо зүйн өндөр мэдрэмжтэй хүн болгож төлөвшүүлэх сургалтын хөтөлбөр” (1974-1982 оны хичээлийн жил) Боловсролын зорилтыг шинэчилж, сургалтын агуулгыг онцлон тодорхойлох зохион байгуулалттай болгох үүднээс сургалтын төлөвлөгөөг боловсруулж хичээлийг сайжруулахыг зорьсон. Хэвлэлийн компаниас “Ёс зүй, гоо зүйн өндөр мэдрэмжтэй хүн болгож төлөвшүүлэх сургалтын хөтөлбөр”, Ёс зүй, гоо зүйн өндөр мэдрэмжтэй хүн болгож төлөвшүүлэх сургалтын практик”, “Ёс зүй, гоо зүйн өндөр мэдрэмжтэй хүн болгож төлөвшүүлэх сургалт ба үнэлгээ” хэмээн 3 цуврал номыг хэвлэн

гаргасан.

- Судалгааны сэдэв “Бие дааж суралцах чадварыг хөгжүүлэх хичээл” (1983-1986 оны хичээлийн жил) Хүүхэд тус бүрийн “бие дааж суралцах чадвар”-ыг хөгжүүлэхийг зорьж, хичээлийг сайжруулахад анхааран судалгааны ажлыг явуулсан. Хэвлэлийн компаниас “Бие дааж суралцах чадварыг хөгжүүлэх хичээл” –ийг хэвлэн гаргасан.
- Судалгааны сэдэв “Мэдэрч, хөдөлж, өөрийгөө хөгжүүлж чаддаг хүүхэд” (1987-1995 оны хичээлийн жил) Хичээлд олж мэдсэн зүйлийг амьдралдаа хэрэгжүүлэх явцад өөрийгөө сайжруулан хөгжүүлж, өөрийгөө шинэчилж явч чаддаг хүүхдийг төлөвшүүлэхийг зорьсон. Хичээл тус бүр· ай тус бүрийг заах хичээлийг сайжруулахын зэрэгцээ хичээлүүдийн зааг хүрээнд баригдахгүй төсөлт ажлын хичээл “Коганэй тайм”-ийг заасан. Хэвлэлийн компаниас “Мэдэрч, хөдөлж, өөрийгөө хөгжүүлж чаддаг хүүхэд-боловсролын шинэ стандартыг бодитоор хэрэгжүүлэх нь”, “Мэдэрч, хөдөлж, өөрийгөө хөгжүүлж чаддаг хүүхэд –хүүхдүүдэд өөрийн гэсэн сайн талыг олуулах хичээл заахын тулд”, “Мэдэрч, хөдөлж, өөрийгөө хөгжүүлж чаддаг хүүхэд-бусадтай хамтран амьдарч чаддаг хүүхдийг төлөвшүүлэх сургууль-” хэмээн 3 цуврал номыг хэвлэн гаргасан.
- Судалгааны сэдэв “Бусадтай хамтран амьдарч чаддаг хүүхдийг төлөвшүүлэх сургууль” (1996-2000 оны хичээлийн жил) Төсөлт ажлын хичээлийн жилийн сургалтын үйл ажиллагааны нарийвчилсан хөтөлбөрийг боловсруулж, хэвлэлийн компаниас “Бусадтай хамтран амьдарч чаддаг хүүхдийг төлөвшүүлэх сургууль-хичээл ба төсөлт ажлын хичээлийн онцлогод тулгуурласан нь-” хэвлэн гаргасан бөгөөд 2002 оноос хэрэгжүүлж эхлэх боловсролын шинэ стандартыг баримталсан сургалтын хөтөлбөрийг багтаасан манай сургуулийн сургалтын өвөрмөц төлөвлөгөөг боловсруулж, хэвлэлийн компаниас “Бусадтай хамтран амьдарч чаддаг хүүхдийг төлөвшүүлэх сургууль-хичээл болон төсөлт ажлын хичээлийн онцлогод тулгуурласан сургалтын төлөвлөгөөг боловсруулах тухай-” -г хэвлэн гаргасан.
- Сургалтын сэдэв “Суралцах баяр баясгаланг мэдэрч, суралцсан зүйлээ амьдралдаа хэрэгжүүлж чаддаг хүүхэд болгож төлөвшүүлэх” (2001-2003 оны хичээлийн жил) Сүүлийн үеийн сургалтын хөтөлбөрийн шаардлагыг хангах үүднээс хүүхдүүдийн бодит байдлыг тодорхойлж, бодит амьдрал ба нийгэмд амьдарч, хөдөлмөрлөх чадварыг төлөвшүүлэх сургалтын байдлын талаар практик дээр судалсан.
- Сургалтын сэдэв “Бодит мэдрэмж төрүүлж, юм бүтээлгэдэг суралцахуйг хөхүүлэн дэмжих-“хүүхдийн логик”-г хөгжүүлэх хичээл-” (2005-2006 оны хичээлийн жил) Суралцах явцын хүүхэд тус бүрийн “суралцахуйн логик”-д анхаарч, тэдгээрийн хамтран суралцах сургалтын үйл явцад бодит мэдрэмж төрүүлж, мэдлэг бүтээлгэдэг суралцахуйг бий

болгохыг зорьсон. 2007 оны 2-р сард, 1500 оролцогчид оролцож судалгааны тайлан танилцуулах уулзалтыг зохион байгуулсан.

- Сургалтын сэдэв “Бие биеэ хүндэтгэн найзлаж, харилцаа тогтоож чаддаг хүүхэд- бусдыг хүлээн зөвшөөрснөөр бий болох суралцахуйн төрөх байдал-” (2007-2008 оны хичээлийн жил) Судалгааны хүрээнд хүүхэд тус бүрийн суралцахуйд зогсохгүй суралцахуйн цаана бий болох хүүхдүүд хоорондын харилцаанд анхааран судалсан. Хичээл дээр бусадтай ярилцаснаар суралцахуйгаа улам өргөжүүлэх, гүнзгийрүүлэх явдал зайлшгүй шаардлагатай бөгөөд тэгэхийн тулд өөрийн санаа бодлыг идэвхтэй илэрхийлэх, найз нөхдийн үгийг сонсч, өөрийн гэсэн санаа бодол, саналтай болох нь чухал гэж үзсэн. Тэгээд хүүхдүүдийн бусадтай харилцах авъяс, ур чадварыг “бусдыг хүлээн зөвшөөрөх” хэмээн үгээр илэрхийлсэн. 2009 оны 2-р сард 1000 гаруй оролцогчтой судалгааны тайлан танилцуулах уулзалтыг зохион байгуулсан.

■Коганэй Бага сургуулийн цаашдын төлөв байдал

Хэтийн төлөвийн 4 чиглэл

○Баклавр ба магистр, докторын оюутнуудыг сургах

- Сургууль дахь дадлага, хичээлийн сайн дурын туслах багш, багшлах дадлагын урьдчилсан ба дууссны дараах удирдамж зөвлөгөө, хичээлийн ажиглалт хийх удирдамж, судалгааны хүрээнд хийх дадлагын ажлыг хүлээж авах г.м.

○Их сургууль г.м.-ийн боловсролын байгууллагатай холбоотой ажиллах • хамтран ажиллах

- Манай их сургуулийн багш, лаборатортой хамтарсан судалгаа явуулах, гадны их сургуулиудтай хамтран ажиллах г.м.

○Хичээл зааж буй багш нарт зориулсан ур чавдарыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах

- Бүс нутгийн загвар сургууль бөгөөд улсын судалгааны цөм сургуулийн хувьд,

○Бүс нутгийн боловсролын судалгааг идэвхжүүлэхийн тулд хамтран ажиллах

- Коганэй хот г.м.-ийн зэргэлдээ бүс нутгуудтай боловсролын судалгааны сүлжээ байгуулах

■Сургуулийн зохион байгуулалтын бүтэц

